# ГАМШИГ, ОСЛЫН ҮЕИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМИЙГ ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НУТАГШУУЛАХ НЬ

У.Амарсайхан. Удирирдлагын
академийн магистрант

**Товчлол.** Энэхүү өгүүллэгээр ослын үеийн удирдлагын систем, тохиолдлын удирдлагын тогтолцооны үүсэл, хөгжил, гамшиг, ослын үеийн Монгол дахь удирдлага, системийн ач холбогдол зэргийг судаллаа.

**Түлхүүр үг:** Гамшиг, осол, ослын үеийн удирдлагын систем тохиолдлын удирдлагын тогтолцоо, систем

**Удиртгал.** Дэлхий дахины хэмжээнд тохиолдол буй байгалын гамшиг осол, аюулт үзэгдлийг багасгах талаар одоо хүртэл дорвитой арга хэмжээг авч чадаагүй бөгөөд хүн төрөлхтний хувьд энэ талаар шийдвэрлээгүй олон асуудал байсаар байна.

Газар хөдлөлт, ой, хээрийн гал түймэр, хүчтэй салхи шуурга, хөрсний гулгалт, үер усны осол, ган, зуд гэх мэт байгалийн гамшиг байнга тохиолдож, түүний хажуугаар үйлдвэрлэлийн томоохон осол гарч, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үлэмж хэмжээний хохирол учруулж байна.

Манай оронд 2013-2020 онуудад жилд дундажаар 23.221 аюулт үзэгдэл, осол тохиолдож, 1020 хүн амь насаа алдаж, аюулт үзэгдэл ослын улмаас 264.3 тэрбум төгрөгийн хохирол урчирсан байна. Тухайлбал:Архангай аймгийн хэмжээнд 2015-2020 онуудад 420 гаруй удаагийн гамшиг, осол, аюулт үзэгдэл тохиолдосноос 46 хүн амь насаа алдаж, тухайн аюулт үзэгдлийн улмаас 3.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Улс орнуудын хувьд гамшигтэй тэмцэх ажлыг удирдан зохион байгуулахын тулд гамшгаас үүсэх үр дагаварт тухайн орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан дүн шинжилгээ хийж, үүнд үндэслэн гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрхэн зохион байгуулах төлөвлөлтийг хийх нь чухал ач холбогдолтой асуудал юм.

Ослын үеийн удирдлагын систем, тохиолдлын удирдлагын тогтолцооны үүсэл. Америкийн Нэгдсэн Улсын Калифорнид хот суурин газар ой, хээрийг хамран тохиолдсон аюулт түймрийн

дараагаар 1970 онд хохирол хэдэн зуун саяар хэмжигдэж, амь насаа алдсан хүмүүсийн тоо маш их болж гэмтэж бэртсэн хүн олон байсан байна. Энэхүү гамшгийн шалтгааныг судалсан мэргэжилтнүүд хор уршгийг арилгах үйл ажиллагааг хүч хэрэгсэл дутсан эсвэл тактикийн алдаа гаргасантай төдийлөн холбоотой байсангүй гэж дүгнэсэн байна. Гайхалтай нь судалгааны үр дүн хор уршгийг арилгах үйл ажиллагаа ганц нэг шалтгаанаас бус **“тааруухан менежмент”-ээс** болсныг харуулсан байна. Иймд: Гал түймрийн хариу арга хэмжээний үеэр анх ослын удирдлагын тогтолцоо ба тохиолдын удирдлагын тогтолцоог боловсруулсан. Энэ ямарваа нэгэн гамшиг осол, аюулт үзэгдлийг хохирол багатай даван туулах, олон газраас ирсэн мэргэжлийн байгууллагын алба хаагч, хүч хэрэгслийг зөв оновчтой зохион байгуулалт оруулж ажиллах арга зүйг олохыг хичээсэн байна.

**Осол гэж юу вэ?** Хүний үйл ажиллагаа эсвэл байгалийн үзэгдлийн улмаас тохиолддог бөгөөд амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах хохирлоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.

Ослын үеийн удирдлагын систем гэж юу вэ?

- Тогтсон стандарттай гамшгийн голомт дахь бүх төрлийн аюулыг тооцсон удирдлагын концепц
- Нэгдсэн буюу хэд хэдэн ослоос үүссэн хүндрэл бэрхшээл, хэрэгцээ шаардлагыг эрх зүйн хязгаарлалтгүйгээр хангаж, нэгдмэд бүтэц, зохион байгуулалтаар ажиллах боломжийг ойлгоно.

Ослын үеийн удирдлагын систем нь ихээхэн уян хатан бүтэцтэй. Ослын үеийн удирдлагын системийн хэрэгцээ шаардлагаас хамаарч, өргөжиж эсвэл багасаж болно. Энэ уян хатан байдал нь зардлыг хэмнэх боломж олгох бөгөөд том, жижиг аливаа ослын үед үр дүнтэй менежментийн хандлага болдог.

Ослын үеийн удирдлагын системийн зорилго: Менежментийн тэргүүн туршлагад тулгуурласан ослын үеийн удирдлагын систем нь

- Ажиллагаанд оролцогчид болон бусад хүмүүсийн аюулгүй байдал
- Тактикийн зорилтын хэрэгжилт

- Хүч хэрэгслийг үр дүнтэй ашиглалтыг хангахад дэмжлэг болно.

“Тохиолдлын удирдлагын тогтолцоо” гэж нийгмийн эрүүл мэнд, эдийн засгийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагуудын удирдлагын цогц үйл ажиллагаа юм.

Ослын үеийн удирдлагын систем тохиолдлын удирдлагын тогтолцоог ашиглах тохиолдолууд: Байгалийн гамшиг-хар салхи, үер, газар хөдлөлт, ой, хээрийн гал түймэр, хүн амьтны халдварт өвчний тархалт, эрэн хайх аврах ажиллагаа, хорт бодистой холбоотой ослууд, террорист халдлага, сэргээн босгох үйл ажиллагаа, хүмүүнлэгийн тусламжийн хуваарилалт болон янз бүрийн төлөвлөгөөт үйл ажиллагаанд ашигладаг.

Ослын үеийн удирдлагын системийн ач холбогдол: ямарч төрлийн, ямарч цар хүрээтэй ослын үеийн хэрэгцээ шаардлагыг хангадаг. Янз бүрийн байгууллагуудын ажилтнууд менежментийн нийтлэг бүтэц нь түргэн дадах боломжтой. Ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтнуудад зохион байгуулалт зохицуулалтын дэмжлэг болдог. Үйл ажиллагаа давхардахаас сэргийлж зардал хэмнэдэг.

Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежментийн дараах сул талуудыг олж тогтоосон. Үүнд:

*- Ажлын хариуцлага дутмаг байдал*

*- Тааруухан харилцаа, холбоо (холбооны хэрэгсэл)*

*-Төлөвлөлтийн үйл явцад алдаа гарсан*

*Салбаруудын үйл ажиллагааны уялдаа холбоо сул*

*- Удирдлагууд хэт их ачаалал авсан*







**Тохиолдлын удирдлагын тогтолцооны давуу тал**

- *Ямар ч хэмжээний, ямар ч төрлийн ослын хариу арга хэмжээний шаардлагад нийцдэг.*
- *Төрөл бүрийн агентлагуудын ажилтнуудыг нэгдсэн удирдлагын бүтцэд хурдан оруулах боломжийг олгодог (Шуурхай штаб).*
- *Үйл ажиллагаа (хариу арга хэмжээний баг) хариуцсан ажилтнуудад логистик, захиргааны дэмжлэг үзүүлдэг (Голомтод ажиллаж байгаа ЭМ ажилтнуудын аюулгүй байдал, хүнс, хувцас гм).*
- *Үйл ажиллагааны давхардлаас сэргийлэх замаар зардлыг хэмнэдэг.*

Манай орны хувьд коронавируст халдвар /ковид-19/ цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба тохиолдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж хэрэгжүүлэн ажиллаж байна. **Жишээ нь**

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН АЛБАНЫ ШУУРХАЙ ШТАБЫН БҮДҮҮВЧ**



**Гамшиг, ослын үеийн Монгол дахь удирдлага.** 2003 онд Тамшгаас хамгаалах тухай" хууль батлагдан гарснаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төр, засгийн дээд байгууллагаас анхан шатны нэгж, иргэддээ хүртэл үйлчлэх, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх тодорхой болж, шат дамжлага цөөрч, удирдлагын шуурхай байдлыг хангаж ажиллах менежментийн тогтолцоо эрх зүйн хувьд илүү боловсронгуй болж үйл ажиллагаа явуулсаар даруй 14 жил өнгөрчээ.

Энэхүү хугацаанд монгол улсад зонхилон тохиолддог нийт 19 аюулт үзэгдэл, ослын үед аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. Үүнд ой, хээрийн болон объектын гал түймэр, цас зуд, хүчтэй салхи шуурга, аадар бороо, үер, аянга, газар хөдлөлт, биологийн гаралтай хүний болон малын гоц халдварт болон халдварт өвчин, хүний үйл ажиллагаантай холбоотой осол (тэсэрч дэлбэрэх бодис, сум галт хэрэгсэл, химийн бодис, бичил уурхай, нурангийн осол, усны осол)-ууд багтана.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бүтцийг авч үзвэл:

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлдэг.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавих үүргийг улсын болон орон нутгийн онцгой комисс гүйцэтгэдэг.

Мөн түүнчлэн төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус улсын болон орон нутгийн албыг байгуулж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

## ДҮГНЭЛТ

Манай улсад хүчтэй цасан болон шороон шуурга, хүн, мал амьтны гоц халдварт өвчин, үер усны аюул, ган, зуд, газар хөдлөлт, цацраг химийн болон уул уурхайн осол зэрэг гамшгийн аюул ихэвчлэн тохиолддог бөгөөд эдгээрийн хор уршгийг арилгах үеийн удирдлагын тогтсон нэг стандарт одоогоор байхгүй байна.

Харин эдгээр гамшгийн аюулын төрлүүд, онцлогоос хамаарч гал түймэр унтраах дүрэм, эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам, уснаас эрэн хайх, аврах ажиллагаа зохион байгуулах журам, химийн бодисын ослын үед ажиллах заавар, уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай обьектод аврах ажиллагааг зохион байгуулах заавар зэрэг дүрэм, журам, заавраар ослын үеийн удирдлагын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Монгол Улсад тохиолдож буй аюулт үзэгдэл, ослын үеийн удирдлагын онцлог, үндсэн шинжүүдийг авч үзвэл төлөвлөлтөд үндэслэгддэг, удирдлагын нэгдмэл, босоо тогтолцоо, уян хатан бүтэцтэй байгаа нь Ослын үеийн удирдлагын системийн бүтэцтэй ижил төстэй боловч томоохон ослын үед төлөвлөлтийн тасаг, санхүү нь удирдлагын штабтаа багтаж удирдлага зохион байгуулалт нь явагддаг онцлогтой. Аюулт үзэгдэл, осол бүр нь нэгдсэн нэг бүтэц, стандартаар явагддаггүй. Ослын үеийн удирдлагын системийн бүтцийг Монгол орны онцлогт тохирсон бүтцийг хэрэглэх нь ослын үед шуурхай ажиллах, шинжилгээ хийх баримт материал сайн байдаг зэрэг олон ач холбогдолтой.

Монгол улсад ослын голомт дээр ажиллах нэгдсэн бүтэц, стандарт загвар, маягт байхгүй аюулт үзэгдэл, осол бүр дээр өөр өөр бүтэц, зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байна.Аюулгүй байдлын ажилтан, холбогч ажилтан гэж байхгүй. Мөн Ослын үеийн удирдлагын систем нь зорилгоо биелүүлэх, мэдээллийг түгээхэд чиглэл өгөх стандарт маягтуудыг ашигладаг. ОҮУС 201, 202, 203, 204, 205, 215 стандарт маягтуудыг аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах үед хэрэглэх боломжтой.

Энэхүү стандарт маягтыг хэрэглэснээр хүч хэрэгслийг үр ашиггүй зарахыг арилгах, хяналттай, аюулгүй, үр дүнтэй, зардал багатайгаар ажиллагаанаас чөлөөлөх үйл явцыг бий болгодог.

## САНАЛ

Ослын үеийн удирдлагын системийн нэршил нь гамшгаас хамгаалах тухай хуульд томьёолсон нэршилтэй нийцэхгүй учир онцгой байдлын үеийн удирдлага гэсэн нэр нь агуулгын хувьд илүү тохиромжтой гэсэн санал дэвшүүлж байна.

Мөн ослын үеийн удирдлага, зохион байгуулалтыг системчлэн ямар ч төрлийн гамшгийн үед ажиллаж болохуйц нийтлэг нэг бүтцийг бий болгох, ослын үеийн удирдлага, зохион байгуулалтыг хангах нийтлэг журам боловсруулах шаардлагатай байна.

Манай улсын хувьд энэхүү системийг ашиглах боломжтой бөгөөд цаашид улам нарийвчилж судлан олон туршилт, дадал сургуулилтыг явуулж бусад хөгжингүй орнуудын адил заавар, журам гарган практикт нэвтрүүлэх үр дүнтэй гэж үзэж байна.

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Номхон Далайн бүс нутгийн улс орнуудын гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх нь “Говийн чоно 2017” Монгол Улс гамшгийн хор уршгийг арилгах дасгал сургууль, туршлага солилцох үйл ажиллагаа. Даланзадгад сум 2017 он хуудас 121

АНУ-ын Ойн алба “Ослын үеийн удирдлагын систем” Анхан/ Дунд шат. Суралцагчийн гарын авлага. УБ хот 2016 он

НҮБ-ын Хүн амын сан 2017 /UNFPA 2017/

Australasian Inter-Service Incident Management System (AIIMS), 2013, /Australian Government, 4th edition/

The New Zealand Coordinated Incident Management System, New Zealand Government, 2014, 2nd edition

“Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам” ОБЕГ-ын даргын 2014 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/339 дугаар тушаалын хавсралт

National Incident Management System (NIMS) Incident Command System (ICS) Forms Booklet. September 2010 FEMA

Тал түймэр унтраах дүрэм” Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 53 дугаар тушаалын хавсралт

“Мал амьтны гоц халдварт өвчний үед онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагааг зохион байгуулах заавар” 2015 оны 12-р сарын 30-ны өдрийн А/344 дугаар тушаалын 1-р хавсралтаар

“Химийн бодисын үед ажиллах заавар” ОБЕГ-ын даргын 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/183 дугаар тушаал

“Тэсэрч дэлбэрэх бодисоос хамгаалах бүлгийн ажиллах заавар”ОБЕГ-ын даргын 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/184 дугаар тушаал.

АНУ-ын Ойн алба “Ослын үеийн удирдлагын систем” Анхан/дунд шат. ОҮУС-ийн маягтууд.2016

Гамшиг судлалын хүрээлэн. Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын статистикийн эмхэтгэл 2004-2016. УБ 2017 хот